



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЗАМЫН-ҮҮД СУМЫН БОРХОЙН БАЯН БҮРД ОНӨ ААТҮГ

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/3/СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2021 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Гэрээт ажилтан Ц.Лүндэгмаа Цахим хаяг: auditlundegmaa@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.24 № 1-6/104

танай _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН БОРХОЙН
БАЯН БҮРД ОНӨ ААТҮГ-ЫН
ДАРГА Ж.УНДРАХБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын -ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Үүнд: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөх, компанийн дүрэмд заасны дагуу эрх, үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, хяналт, хэвийн үйл ажиллагааг хангах бодлого, үр дүн зэрэг болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 1-р сарын 01	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	5,466,515
1.1.2	Дансны авлага		486,000
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		-
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	20,000	1,089,200
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,000	7,041,715.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,000	7,041,715.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.3	Татварын өглөг	-	1,139,572
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	1,139,572
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	-	1,139,572
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) төрийн		
2.3.2	б) хувийн	20,000	20,000
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	5,882,143.25
2.3.10	Тайлант үеийн ашиг		5,882,143.25
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,000	20,000
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,000	7,041,715.25

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

төгрөгөөр		
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-сарын31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	15,475,000.00
2	Борлуулалтын өртөг	
3	Нийт ашиг (алдагдал)	15,475,000.00
4	Түрээсийн орлого	
5	Хүүний орлого	-
6	Ногдол ашгийн орлого	
7	Эрхийн шимтгэлийн орлого	
8	Бусад орлого	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,375,900.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,945,669.00
11	Санхүүгийн зардал	
12	Бусад зардал	617,715.75
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	
17	Бусад ашиг (алдагдал)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,535,715.25
19	Орлогын татварын зардал	653,572.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	5,882,143.25
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,882,143.25
23	Бусад дэлгэрэнгүй орлого	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	
	Бусад олз (гарз)	
24	Орлогын нийт дүн	
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр						
№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Эздийн өмчийн бусад хэсэг	Нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	20,000.00				20,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл					-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			5,882,143.25		5,882,143.25
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-

6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00		5,882,143.25		5,902,143.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	төгрөгөөр
		2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	15,475,000.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	15,475,000.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	
	Буцаан авсан албан татвар	
-	Татаас, санхүүжилтийн орлого	-
	Бусад мөнгөн орлого	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,008,484.75
	Ажиллагчдад төлсөн	2,630,364.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	267,348.97
	Бараа материал худалдан авахад төлсөн	6,384,740.0
	Ашиглалтын зардалд төлсөн	617,715.8
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-
	Татварын байгууллагад төлсөн	108,316.00
	Бусад мөнгөн зарлага	-
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,466,515.25
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,466,515.25
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,466,515.25

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Ж.Ундрахбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу хөрөнгийн тооллого хийх, татварын тайланг үнэн зөв мэдээлэх, шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 11-ээс 2021 оны 02 дугаар сарын 12-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт ажилтан Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 02 сарын 09-ны өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллагын үйл ажиллагаа нь ойн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, ойжуулалт, ойн аж ахуй болон ойн ашиглалтын арга хэмжээний шинэ техник технологийг турших, нутагшуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлтэй.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ санхүүгийн болон орлого үр дүнгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлаагүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын тайлангийн зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 10,008.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 200.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7021.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	5,466.5	5,466.5
Авлага	0	486.0	486.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	20.0	1,089.2	1,069.2
Үндсэн хөрөнгө	0	0	0
Нийт хөрөнгө	20.0	7,041.7	7,021.7
Өр төлбөр	0	1,139.6	1,139.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	20.0	5,902.1	5,882.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20.0	7,041.7	7,021.7

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,466.5 мянган төгрөгөөр өссөн нь тус байгууллага 2020 оны 6 дугаар сараас ногоон байгууламж тариалах үйл ажиллагаа эхэлснээр Наран тээг ХХК-аас 15,475.0 мянган төгрөгийн орлого орж үйл ажиллагаанд зарцуулаад үлдсэн мөнгө байна.

Авлага дансны үлдэгдэл 486.0 мянган төгрөг болж 486.0 мянган төгрөгөөр өссөн нь иргэдээс ХХОАТ-ыг дутуу суутгасан татварын авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 1069.0 мянган төгрөг болж 1069.2 мянган төгрөгөөр өссөн бичиг хэргийн материал болон ААМ-ын үлдэгдлээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,139.6 мянган төгрөг болж 1,139.6 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын өр 486.0 мянган төгрөг, ААНОАТ-ын өглөг 653.6 мянган төгрөгийг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,470.9 мянган төгрөг болж 5,882.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашгийн дүнгээс шалтгаалжээ.

Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн орлого үр дүнгийн тайлангаар нийт орлого 15,475.0 мянган төгрөг байна.

Нийт зардал 8,939.3 мянган төгрөг байгаагаас цалингийн зардал 2,806.4 мянган төгрөг, бараа материалын зардал 5,375.9 мянган төгрөг, бусад зардал 757.0 мянган төгрөг буюу усны төлбөр, банкны үйлчилгээний хураамж зэрэг байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн төлөвлөлт

Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ 2020 онд бизнес төлөвлөгөө батлуулаагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлэл оруулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага нь 2020 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба анх удаа санхүүгийн тайлангаа баталгаажуулж байгаа болно.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 2,138.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2138.4 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн, төлбөрийн акт, албан шаардлага өгөх алдаа зөрчил байхгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц бусад асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Эд хариуцагчийн тайланг НББ-тэй тулган шалгахад НББ-д бараа материалыг үлдэгдэлгүйгээр тайлагнасан байна. Эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй байна. Хөрөнгийн үлдэгдлийг нотлох зорилгоор одоогийн байдлаар бэлэн байгаа хөрөнгүүдийн зургаар- бодитоор оршин байгааг нотолсон болно.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:

1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/;
2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" гэсэн заалттай нийцээгүй, оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан тооллого хийх хугацааг баримтлан тооллого тооцоог зохион байгуулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим сайтад үндсэн үйл ажиллагааны орлогын дүнг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;" , 5.1-д "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна: 5.1.1.шилэн дансны бие даасан цэстэй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

2.2. Эрсдэл: Хууль эрх зүй зөрчигдөх, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Татварын тайланд гэрээгээр ажилласан, 10 хувийн татвар суутгасан 1 хүний 420.0 мянган төгрөгийн гэрээт ажлын хөлсийг үндсэн ажиллагсдын хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого хэсэгт тайлагнасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29.1.3-т “суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл: Хууль эрх зүй зөрчигдөх, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 29.1.3 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.22			ДГА-2021/3/СТА-ААТҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хөрөнгийн тооллого	0	Зөвлөмж өгсөн	Дарга	Ж.Ундрахбаяр
2	Шилэн дансны мэдээлэл	0	Зөвлөмж өгсөн	Дарга	Ж.Ундрахбаяр
3	Татварын тайлан	0	Зөвлөмж өгсөн	Дарга	Ж.Ундрахбаяр
ДҮН		0			